

## **“МАХ ИМПЭКС” ХК-ИЙН 2020 ХАГАС ЖИЛИЙН ОНЫ ҮЙЛ АЖИЛАГААНЫ ТАЙЛАН**

2020 оны 07 дугаар сарын 31

Мах импэкс ХК-ийн ТУЗ-өөс 2019 онд хийсэн ажлын тайлангийн хурлаар тавьсан зорилтуудыг ханган биелүүлэх зорилгоор бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа хийж компанийн хэмжээнд бизнес төлөвлөгөө, техник зохион байгуулалтын төлөвлөгөө гарган ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөн ажиллаа.

Дэлхий нийтийг хамарсан хөл хорионоос шалтгаалан махны экспортыг хязгаарласан тул хиаман бүтээгдэхүүн, хонь, адууны махны үйлдвэрлэл тодорхой хувиар буурч махны экспорт хэсэг хугацаанд таслалдсан. Засгийн газраас арга хэмжээ авсны үр дүнд одоогоор адууны мах, дулааны аргаар боловсруулсан махыг экспортолж байгааг албаныхан хэлж байгаа боловч цар тахалтай холбоотойгоор зарим нэг хүндрэл гарч тайлант хугацаанд 50 тонн адууны мах БНХАУ-руу экспортолсон байна.

Нийслэлийн хүн амын 2020 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан нөөцийн махыг худалдаанд гаргаж эхэлсэн. Иргэдийн дунд махны амт, чанарт сэтгэгдэл өндөр, эрэлт ихтэй байсан тул Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/309 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан ажлын хэсэгтэй хамтран нөөцийн махны өргөтгөсөн худалдааг зохион байгуулж ажилласан.

2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл 32 дулгүүртэй нөөцийн мах худалдах гэрээ байгуулан хамтран ажиллаж

Үхрийн мах 191,6 тн

Хонины мах 199,9 тн

Ямааны мах 100,8 тн

“Нөөцийн мах”-ны өргөтгөсөн худалдаагаар

Хонины мах 127,4 тнн

Ямааны мах 10,6 тн-ыг худалдан борлуулж нийт 4 358 910 мянган төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Мөн Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоолоор баталсан “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”-ын заалт, Засгийн газрын мөн оны 23, 26 дугаар тэмдэглэлийн хүнсний хангамж, үнийн түвшинг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд Нийслэлийн хүн амын хэрэгцээнд 2020-2021 онд худалдан борлуулах хонь, ямаа, үхрийн махыг нөөцөнд бэлтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн техник зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Үүнд:

- Цахилгаан цех, дахин дамжуулах подстанцын дээврийг шинэчлэх ажилд 72 сая төгрөг зарцуулсан.
- Мах ангилан боловсруулах үйл ажиллагаанд зориулан БНХАУ-ийн Hebei Xiaojin компаниас 50,3 сая төгрөгийн махны машин худалдан авсан.
- Мах хадгалах зоориудын дулаан алдагдлыг бууруулснаар хүйтэн үйлдвэрлэлд зарцуулах хөрөнгө багасна. Үүний тулд нийт 5 зоорины 7 хаалгыг шинээр хийж суурилуулахад 4,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн
- Хөргөлтийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд 16 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аммиакны болон усны насосуудыг худалдан авч суурилуулсан, 200 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ОХУ-аас хөргөлтийн шингэн боломж аммиакыг импортлон оруулж ирсэн байна.
- Мах боловсруулах үйлдвэрийн шуллагааны цехэд 2 ширхэг нерж тэрэг, гулууз мах зөөвөрлөх тэрэг 3 ширхэгийг шинээр хийсэн.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

/Г.БУДРАГЧАА/

/Н.МАРАЛСҮРЭН/